

## ЭРДЭНЭ РЕСУРС НЬ УЛААН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙГ 100% ЭЗЭМШИН, ХӨНДИЙ АЛТНЫ ДҮҮРЭГТ БАЙР СУУРИА БЭХЖҮҮЛЭВ

### Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот  
2020.12.10

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь Лидер Эксплорэйшн ХХК-ийн 49%-ийг худалдан авч, Баян Хөндий Алтны ордтой залгаа орших Улаан тусгай зөвшөөрлийн талбайг 100% эзэмших болсныг мэдээлэхэд таатай байна.

### Онцлох мэдээлэл:

- Улаан нь Хөндий дүүрэгт орших хэд хэдэн порфир, эпитеpmаль хэтийн төлөв бүхий бүсүүдийн нэг юм. (Хавсралт зурагтай танилцана уу)
  - Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь литокапын суурь доорх элэгдэлд орсон порфирын системтэй уялдан гидротермийн томоохон хувирлын системийг агуулдаг. Үүнд:
    - Филлитийн (Кварц-серицит- пирит) хүчтэй хувирсан 3 км-ийн диаметр бүхий талбай
    - Турмалин брекчтэй холбогдсон алт-зэсийн туслах эрдэсжилт
    - Филлитийн бүстэй зэргэлдээ орших иллитийн хувирсан галт уулын кварцын судалд алт илэрсэн
- Компани хэд хэдэн эпитеpmаль алт болон порфирын зэсийн хэтийн төлөв бүхий талбайг агуулж буй Хөндий-Улаан хувирлын системийн дийлэнхийг багтаасан талбайг 100% эзэмшин, нэгтгэлээ.
- Баян Хөндий Алтны ордын зэргэлдээ орших эрдсийн хайгуулын тусгай зөвшөөрлийн байр сууриа бэхжүүлэв.
  - Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь Баян Хөндий орд, Хар Морь болон Алтан Сум талбайн баруун талд зэргэлдээ оршдог
  - Эрдэнэ Ресурсийн хэтийн төлөв бүхий Хөндий Алтны Дүүргийн талбайг 17,004 га (170 км<sup>2</sup>) болгон өргөжүүллээ.
- Хайгуул хязгаарлагдмал хийгдсэн боловч геологийн хувьд өндөр ач холбогдолтой
  - Өнгөрсөн гурван жилийн хугацаанд хязгаарлагдмал өрөмдлөгийн хөтөлбөр, зураглал, дээжлэлт болон геофизикийн судалгаа хийгдсэн.
  - Гадаргын дээжлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд 2021 оны 1-р улиралд өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэхээр төлөвлөсөн.

### Тодруулга:

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли: "Эрдэнэ Ресурс нь дэлхийн томоохон алт, зэсийн бүсүүдийн нэг болох Монгол Улсын баруун зүгт хязгаарлагдмал хайгуул хийгдсэн бүсэд

эпитеpmаль болон порфирийн ордуудыг нээн илрүүлсэн тэргүүлэгч хайгуулын компани болоод байна. Улаан тусгай зөвшөөрлийн талбай болон Хөндий Алтны Дүүрэгт эпитеpmаль алт, порфирийн зэсийн томоохон нээлтүүдийг хийх боломжтой. Улаан тусгай зөвшөөрлийн талбайг бүрэн эзэмших болсноор бид хайгуулын хөтөлбөрүүдийг идэвхтэйгээр үргэлжлүүлэх болно.

“Бид 2021 оны 1-р улиралд төлөвлөсөн өрөмдлөгийн хөтөлбөрөөс өмнө Улаан тусгай зөвшөөрлийн талбайд гадаргуун дээжлэлт хийж дуусгасан. Компани хэдийгээр Баян Хөндийн Алтны Төслийг олборлолтын шатанд хүргэх гол зорилготой ч зэргэлдээ орших талбайд хайгуулын хөтөлбөрүүдийг гүйцэтгэхээ энэхүү шинэ алтны дүүрэгт нөөц нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

### Улаан тусгай зөвшөөрлийн талбай

Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн баруун талд зэргэлдээ оршдог. Тусгай зөвшөөрлийн талбай нь нийт 1,780 га талбайг хамардаг бөгөөд порфирын зэс болон эпитеpmаль алтны системийн шинж чанар бүхий кварц-серицит-пирит (QSP)-ийн хүчтэй хувирлын томоохон бүсийг (ойролцоогоор 3км диаметр бүхий) агуулдаг.

Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь томоохон хувирлын бүсийн зүүн өмнө зүгт байрладаг ба энэхүү хувирлын бүс нь зүүн хойш чиглэн 10 км үргэлжилдэг. Энэхүү хувирлын тренд нь Баян Хөндий алтны ордыг агуулагч цагаан гялтгануур, серицитийн гадна бүс болон серицитийн хувирлын захаар хүрээлүүлсэн хүчтэй хоёрдогч цахиурын төв бүсийг агуулдаг. Энэхүү зүүн өмнөд трендийн дагуу хувирсан бүсэд Улаан, Баян Хөндий болон бусад эрдэсжсэн хэтийн төлөв бүхий талбай (Хар Морь ба Алтан Сум талбай) багтаж байгаа нь зүүн өмнөд трендийн хагарлын дагуу бүс нутгийн структурын тэлэлтийн тэгш бус байдал ба томоохон галт уул - плутоник төвтэй холбогдож байна. Улаан тусгай зөвшөөрлийн талбай дахь хэтийн төлөв бүхий болон зэргэлдээ орших бүсүүдийн эрдэсжилт, хувирлууд нь томоохон структурын дагуу давхцаж эсвэл сунаж эрдэсжсэн нуман шилжилт бүхий баялаг магмын арлын нуман хувиралтай уялдаж байна.

Эрдэнэ Ресурс 2017 оны 3-р улиралд Улаан төслийн 51%-ийг эзэмшсэнээс хойш гадаргын нарийвчилсан зураглал, геохимийн судалгаа болон геофизикийн хөтөлбөрүүдийг гүйцэтгэсэн. Түүнээс гадна, тусгай зөвшөөрлийн талбайн төв хэсэгт 1,750 тууш метрийн хоорондоо өргөн зайтай 5 цооног өрөмдсөн. Өнөөг хүртэл тодорхойлогдсон хувирал болон эрдэсжилтэд төв кварц-серицит-пирит (“QSP”) бүс багтаж байгаа бөгөөд үүнийг эгц босоо тэнхлэгийн дагуу бүрхэгдсэн болон штокверк кварц-пиритийн судлууд (D судлууд) ба орон нутагт элбэг тархсан пирит, кварц-мана-пирит матрицтай гялтгануур брекч бүхий Au, Cu, Mo хөрс болон чулуун дээжийн гажилттай пропиликт хувирлын гадна бүс тойрон оршиж байна. Энэхүү хувирлын тархалт ба хэлбэр нь нийтлэг порфирын системийн эрдэсжсэн кварц штокверк бүсийн доор оршдог кварц-серицит-пирит (“QSP”) -ийн хувирлын дээрх литокапийн суурийн доороос элэгдсэн порфирын системтэй уялдаж байна.

Зэргэлдээ орших Баян Хөндий бага сульфиджилт бүхий алтны систем нь порфирын хэлбэрийн хувиралтай уялдан өндөр температур, калийн ба филлитийн хувирлын бүстэй давхардан оршиж байна. Хоёр талбайн хоорондын зай ойр байгаа нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн цахиур ба аргиллитийн хүчтэй хувирал нь Улаан порфирийн тайлалтай холбоотой байх магадлалтай. Түүнээс гадна, Баян Хөндийн эрдэсжсэн бүсийн баруун хойд зүг рүү илт налсан байдал нь Улаан тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хязгаарын дагуу гүндээ хэтийн төлөв бүхий бүс байх боломжтойг харуулж

байна. Эрдэнэ Ресурс нь 2021 оны 1-р улиралд төлөвлөсөн өрөмдлөгийн хөтөлбөрөөр дээрх онолуудыг шалгахар төлөвлөж байна.

Компани нь 2020 оны 12-р сарын эхээр Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Лидер Эксплорэйшн ХХК-ийн үлдсэн 49%-ийг Монгол Улсын татварын байгууллагад төлж барагдуулах төлбөрүүдийг оролцуулан 750,000 ам.доллартай тэнцэх монгол төгрөгөөр худалдан авсан. Худалдан авалтыг хийснээр худалдагч талтай ямарваа нэгдмэл ашиг сонирхолгүй болсон боловч Sandstorm Gold-д борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("БЦАТ")-ийн 1% төлөх үүрэгтэй. Улаан хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 6 дахь жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол Улсын Ашигт Малтмалын тухай хуульд заасан нөхцөлүүдийг хангаснаар хайгуулын тусгай зөвшөөрлийн 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон хөрвүүлэх боломжтой.

### Хөндий Алтны Дүүргийн тухай

Эрдэнэ Ресурсийн төслүүд нь Төв Азийн Орогены бүслүүрийн (хавсралт зурагтай танилцана уу) зүүн хэсэгт байрладаг. Энэхүү бүслүүр нь Кумтор (14 сая унц Au), Алмалик (25 сая унц Au), Мурунтау (140 сая унц Au) болон Оюу Толгой (62 сая унц Au) зэрэг алт, алт-зэсийн хэд хэдэн том ордуудыг агуулдаг. Бүслүүр дэх ороген, порфир, эпитермаль ордууд нь ихэвчлэн Палеозойн нумын структурын орчинтой уялдан адил томоохон металлоген ба тектоник үйл явцтай холбогддог. Эдгээр ордууд нь галт уул-плутоник идэвхжилтийн төвд трансформ хагарлаас үүдэн хэсэгчлэн тохиолддог бөгөөд энэ нь зүүн суналын гулсалттай холбоотой ба субдукцийн үйл явцад үүссэн мантийн чийрэгтэй уялдан бүс нутгийн хагарлаас салаалан үүссэн. Бүслүүрийн дагуу зүүн хойд хувирлын структурууд нь алт, зэсийн ордын гарал үүсэлд чухал ач холбогдолтойг харуулж байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хэд хэдэн нээлтийг хийсэн тэргүүлэгч хайгуулын компани юм. Компани нь хайгуулын ажлын хүрээнд томоохон ордуудын голлох шинж чанаруудыг судалснаас гадна дээр танилцуулсан Монгол Улс дахь Палеозойн нумын террейний үнэлгээг хийсэн. Үүний үр дүнд бид геологийн болон структурын орчинд үндэслэн 400 км үргэлжлэх Эдрэнгийн террейнд төвлөрөн ажилласан. Эдрэнгийн террейний зүүн хэсэгт хийсэн хайгуулын хөтөлбөрөөр өндөр хэтийн төлөв бүхий зорилтот талбайнуудыг тодорхойлсон. Өнөөг хүртэл хамгийн өндөр ач холбогдол бүхий гурван хэтийн төлөв бүхий талбайг судалсны үр дүнд Хөндий Дүүрэгт гурван ашигт малтмалын нөөцийг тодорхойлсон. Үүнд: Алтан Нар (АН) алт-полиметаллын орд, Баян Хөндий (БХ) алт мөнгөний орд болон Алтан Сум, Хар Морь Хөвийн Хар, Оюут Хөндий зэрэг алт, зэсийн хэд хэдэн илрэлийг нээн илрүүлсэн. Баян Хөндийгөөс зүүн зүгт 35 км-т молибден-зэс порфирын Зуун Мод ордыг нээсэн. Хөндий Дүүрэгт бүс нутгийн структурын трендтэй холбоотой эрдэсжилтийн систем, порфирын зэс, зэс-молибден, дундаж сульфиджилт, өндөр сульфиджилт, бага сульфиджилт бүхий нумын бүрэн спектр багтаж байна.

Эрдэнэ Ресурсийн хайгуулын хөтөлбөрийн үр дүнд тулгуурлан Хөндий Дүүрэгт алт, зэсийн шинэ нээлтүүдийг хийх боломжтой гэж үзэн, системчилсэн судалгаа, хайгуул болон хөгжүүлэлтийн ажлуудыг энэхүү эрдэсжсэн дүүрэгт үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.

### Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд

багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) -оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

### Холбоо барих

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал  
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>


Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

# GOLD DEPOSITS OF THE EASTERN PORTION OF THE CENTRAL ASIAN OROGENIC BELT

## Highlighting Mongolia's Edren Terrane and Khundii Gold District



-  Gold Deposit
-  Copper Deposit
-  Copper-Gold Deposit



500 km

# KHUNDII DISTRICT PLAN MAP

## Landsat with Regional Structure (after Kloppenburg) and Major Mineral Occurrences/Deposits




10 km

	ERD License		Gold
	Deposit		Copper
	Prospect		Molybdenum

# BAYAN KHUNDII – ULAAN ALTERATION ZONE

Landsat, with Conceptual Structural Jog, Gold Deposit and Au-Cu Prospects



# LOOKING NW FROM KHUNDII LICENSE TO ULAAN ALTERATION ZONE

